

IX–X ЗУУНЫ ТӨВ АЗИЙН НҮҮДЭЛЧДИЙН ТҮҮХЭНД ХОЛБОГДОХ НЭГЭН СУРВАЛЖИЙН ЗАРИМ МЭДЭЭНИЙ ТУХАЙД

Б.Батсүрэн, Д.Наранжаргал

ШУА-ийн Түүхийн хүрээлэн, bbarangas@yahoo.com

Умард Сүн улсын Куан И Тайзун хааны Тайпин Шинго-ийн зургадугаар оны V сараас мөн хааны Юнси-гийн анхдугаар оны IV сарын хугацаанд¹ Гаочан болон Бешбалыкаар төвлөрөн нутаглаж байсан Хуйгэ (Уйгур) улсад элчээр томилогдож очсон түшмэл Ван Яньдэ-гийн аян замын тэмдэглэлд нэр дурдагдсан зарим аймагт хамаарах ганц нэг саналыг энэ өгүүлэлд дурдах болно.

Ван Яньдэ 981 оны 5 дугаар сард Сяжөү хотоос гарч одоогийн Ордос нутгийн зүүн хэсгээр аялан явсаар Хатан голыг гатлан баруун зүг эргэн Эзний голын адаг хүрчээ. Цааш Мазуншань болон Вансяньлинь уулыг дайрч Ижөү улмаар Гаочанд очжээ. Тэр ийн аялж явахдаа одоогийн Иньшань уулаас Эзний гол орох замдаа Liu-k'o (Люкэ) цөл, Lou-tzu² (Лоузы) уулыг дайрч өнгөрөөд дараа нь VIII–IX зуунд уйгурууд эзэмшиж байсан гэдэг Tu-tu³ (Дуду) уул хавиар нутаглаж байсан Wo-yang-liang Hai-t'e (Воянлянхэтэ) аймагт очжээ. Дараа нь Хиданы хил хавиар нутаглах T'ai-tzu Ta-ch'ung (Тайзы Дачунь) аймаг болон Ta-kan Yü-yüeh (Дагань Ююэ)-ийн хүү Wu Ti-yin⁴ (Ү Димү)-ий аймгийг дайрч өнгөрчээ.⁵

Энэхүү Дагань Ююэ Ванзы (Ta-kan Yü-yüeh Wang-tzu)-ийн аймгийг Ван Яньдэ “эд нар Есөн Татар (Жиүзү Датань) дотроо хамгийн хүндтэй” нь гэж тэмдэглэсэн байна. Дагань Ююэ-ийн толгойлсон *татар* аймгийн талаар өгүүлснийхээ дараа Ван Яньдэ *татар* болон *хиданы* тухай маш сонирхолтой нэгэн мэдээг дурджээ. Түүнд:

6:—傳曰契丹舊爲回紇牧羊蓬鞞舊爲回紇牧牛

7:—回紇徙甘州契丹蓬鞞遂各爭長攻戰次歷問

- 1 Энэ нь одоогийн бидний хэрэглэж буй цаг тооллоор 981.6.5-7.4-ноос 984.5.4-6.1 болно. Ром тоогоор билгийн улирлын сарыг харин Араб тоогоор аргын улирлын сар өдрийг тэмдэглэнэ.
- 2 Liu-k'o цөлийг одоогийн Өмнөд Монголын Урад хошууны нутагт байх гэж Манжийн түүхч Дин Цянь (1843–1919) өгүүлснийг Өзкан Изги дэмжсэн ба харин Lou-tzu уулын талаар дурдсан зүйл алга байна. [Zin elzisi Wang Yen-te'nin Uygur Seyahatnamesi. Izkan Izgi. Ankara, 2000. p. 45, n 8; p. 46, n 85]
- 3 Майкл Р. Дромпп тус уулыг Tutuq? гэсэн түрэг үг байж болох талаар болгоомжтой хэлсэн бололтой. [Drompp M.R. Tang China and the Collapse of the Uighur Empire. A documentary history // Brill's Inner Asian Library. Vol. 13, Brill-Leiden-Boston, 2005. p. 128] Дуду буюу тутук цолыг Уйгурт 646 оноос үзэгдсэн гээд Тангийн үед уйгуруудын сууж байсан нэгжийн захирагчид энэ цолыг хэрэглэж байсан гэж Б.Өгэл бичжээ. [Ugel B. Ein Tor Nach China Im 10. JHDT //Central Asiatic Journal. Vol. VI, 1961. s. 175]
- 4 Уг нь wüdmimш гэж буй. Судлаач Сүрбадрах мөн ингэж уншжээ. [Сүрбадрах. Монгол үндэстний язгуур үүсэл. Сүх монголчлов. Үндэстний хэвлэлийн хороо, 1988. т. 141]
- 5 Zin elzisi Wang Yen-te'nin Uygur Seyahatnamesi. Izkan Izgi. Ankara, 2000. pp. 87-89

6:—Хууч яриагаар Цидань урьд Хуйгэ—[ийн] хонь ямааг хариулдаг, Дада урьд Хуйгэ—[ийн] үхэр хариулдаг [байсан].

7:—Хуйгэ Ганьжоу [руу] нүүсэн—[ээр] Цидань, Дада [нар] урт хугацаанд хоорондоо хэн нь тэргүүлэхийн төлөө өрсөлджээ⁶ гэж өгүүлсэн байдаг.

Ван Яньдэ—ийн аян замын тэмдэглэл дэх энэ мэдээний талаар бид тусгайдаа нэг өгүүлэл нийтлүүлсэн⁷ тул одоо воянлянхэтэ аймгийн талаар дурдана.

Воянлянхэтэ (wò yáng liáng hé tè) аймгийн нэрийг С.Жюльен *ngo-liang-khe-tai* гэж уншсан бол Б.Өгэл *воянлянхэтэ-г урианхат* (uriankhat?) аймаг байж болох талаар дурдаад улмаар Дудушань уул нь одоогийн Алашань уул байх гэжээ.⁸ Тан улсын сүүлээр *түрэг-шато* болон *урианхат* аймаг хил залгаж байсан гэж бичсэн Дин Цянь, тэдний нутаглаж байсан Дудушань-ийг одоогийн Гурван Сайхан уул гэж оноожээ. Харин Өзкан Изги *урианхат* ба *түрэг-шато* аймаг хиллэж байсан гэх дүгнэлт нь баттай баримтгүй гээд мөн Дудушань уулыг одоогоор найдвартай оноогоогүй хэмээв.⁹ *Воянлянхэтэ* аймгийг судлаач Сүрбадрах шууд *урианхай* гэж бичсэн байдаг.¹⁰

Эдгээр судлаачын санал зөв эсэхийг хэлэхийн өмнө эртний монгол аймаг болох *урианхат* нарт холбоотой хэдэн баримт дурдъя.

Иран орны засгийн эрхийг бараг нэгэн зууны турш барьж асан Монголын Эл хаант улсын хаадын сан хөмрөгт хадгалж байсан бичиг сэлтэд тулгуурлан бүтээсэн «Сударын чуулган»-д *урианхай* нэрээр хоёрын ч зэрэг аймгийг нэрлэснийг бүгд мэднэ.

Урианхат нэрээс бага зэрэг ялгаатай *Урианха/урянка* нэрээр “үүсч салбарласан нь эрт цагт болж өнгөрсөн ... одоо цагт *монгол* хэмээн нэрлэгдэж буй ч анхандаа тэдний нэр тийм байгаагүй” нэгэн аймгийг оноон нэрлэжээ. Сэлэнга мөрний нөгөө этгээдэд монголчуудын суудаг нутгийн хамгийн захын хязгаар Баргужин Төгүм болон түүний ойр хавьд *баргут, кори, төлэс, тумат* мөн *ойрат, булагачин, хэрэмүчин* зэрэг аймгийн хамт нутагладаг *хойин урианха/урянка* хэмээгдэх “энэ аймаг бусад *урианхат/урянка* нартай огт холбоогүй: тэд энэ нэрийг тэдний гэр ойд байдаг учраас авчээ. Тэд хэзээ ч майхан, асартай байгаагүй; тэд хувцасаа амьтны арьсаар хийдэг; тэдэнд үхэр хонь байдаггүй; эдний оронд тэд уулын үхэр, уулын хонь [аргаль] болон уулын хоньтой төстэй жүр/зүр (jür)–ийг тэжээдэг; тэд эднийг барьж аваад сүүгий нь ууж, махы нь иддэг” ажээ. Өөрөөр хэлбэл энэхүү *хойин урианха* аймаг нь үүсэл гарвал, ахуйн хэв маягаараа монгол хэлт нүүдэлчдээс арай ялгаатай нь дээрх мэдээнээс харагдах байх.

Харин нэгэн цагт “Эргүнэ хун одсон тэрхүү хоёр хүнээс гарвалтай нь мэдэгддэг;

6 Çin elçisi Wang Yen-te'nin Uygur Seyahatnamesi. Özkan Izgi. Ankara, 2000. pp. 88, 78

7 Батсүрэн Б. Монгол–Татарын түүхийг нэхэн мөшгөх нь //Studia Historica. Tom. XXXVIII, fasc. 4. УБ., 2008. т. 59-89

8 Julien S. Notices sur les pays et les étrangers, tirees des geographies et des annales chinoises; III, Les Oigours // Journal Asiatique. Ser. IV, Tome IX. 1847. p. 53; Ögel B. Ein Tor Nach China Im 10. JHDT // Central Asiatic Journal. Vol. VI, 1961. s. 175

9 Çin elçisi Wang Yen-te'nin Uygur Seyahatnamesi. Özkan Izgi. Ankara, 2000. pp. 46, 47. n. 87, 88

10 Сүрбадрах. Монгол үндэстний язгуур үүсэл. Сүх монголчлов. Үндэстний хэвлэлийн хороо, 1988. т. 141

өсч, үржих замаар ... олон тоотой болсон ... дөрвөн зуу орчим жилийн дотор тэднээс олон салбар гарч, тоогоор бусдаа давсан; ... Эргүнэ хунд байсан тэрхүү жинхэнэ монголчуудаас үүсэн [гарч] тус бүртээ тусгай нэр хочыг зүүх [бологсдын нэг нь] *урианхат/урианкат* ..." аймаг бөгөөд Эргүнэ хун хэмээх давчуу хөндийгөөс нүүн гарахдаа нэгэн хэц, цохиот уулыг сонгож энгэр бэлийг хайлуулан төмөр гарган авч улмаар уудам нутагт нүүхэд хианаас удамт гол салбар аймаг мөн нүгүзээс салбарласан урианхат аймаг голлох үүргийг гүйцэтгэж хөөрөгдөлцсөн байна.¹¹

Монгол аймгуудыг Эргүнэ хунаас гарахад нь тэргүүлж байсан язгууртан бол «Сударын чуулган»-д өгүүлснээр Бөртэ чинэ/чина ажээ. Тус сурвалжид энэ талаар ийн өгүүлжээ. "Тэдний амьдрал ахуйн эхлэлийн нарийн ширийний талаар итгэл бүхий Түрэгийн түүх хуучлагчид ярихдаа, Монголын бүх аймаг, Эргүнэ хун руу одсон тэр л хоёр хүний ургаас [насл] үүссэн гэдэг. Тэндээс гарагсадын дунд хэдэн аймгийн тэргүүн бөгөөд удирдагч Бөртэ Чина хэмээх нэртэй нэгэн хүндтэй ноён байсан ба түүний ургаас Алан Гоа-ийн нөхөр Добун Баян мөн өөр бусад аймаг язгуурлаж салжээ" хэмээжээ. Мөн судар бичигт "... хамгийн дээд үнэн соёрхсоноор Чингис ханы өвөг дээдсийн гүрэн, улс мэдэгдэж Чингис ханы ураг болон бүх Монголын салбар дахь түүний угсааныхан үүсвэрлэсэн Добун Баян, Алан Гоа-ийн салбар ялгагдаж тодров. Хэдий тухайлсан он цаг байхгүй болов ч барагцаа багцаагаар дөрвөн зуугаад жил болох байх, яагаад гэвэл эрдэнэсийн хөмрөгт байдаг тэдний судар бичгийн хэсэг бүлгийн утга агуулга мөн хашир өтгөсийн хүүрнэдэг сэцэн билигт үлгэр домгоор бол: тэд, Аббас-ийн угсааны халифатын эхээр болон Саманидуудын хаанчлалын үе гэхэд байж одоог хүрчээ гэдэг нь тодорч илэрхий болов"¹² гэж бичсэн байдаг. «Сударын чуулган»-д өгүүлсэн мэдээг үндэслэн Л.Билэгт монгол аймгуудын Эргүнэ хун руу нүүсэн, тэндээс гарсан цаг хугацааг тогтоосон байдаг. Түүнийг судалгааг үндэслэвэл монгол хэлтэн аймгууд Эргүнэ хунд IV зуунаас VIII зууны II хагас хүртэлх 400-450 жилийн турш нутаглаж байжээ.¹³

Эргүнэ хунд *монгол* аймгууд нутаглаж байхад *нүгүз* аймгаас *урианхат* нар салбарласан гэх «Сударын чуулган»-ы мэдээ болон Л.Билэгтийн Эргүнэ хуны монгол аймгуудад холбогдох он цагийн талаарх судалгааг харьцуулж үзвэл *монгол урианхат* аймгийн үүсэл VIII зуунаас урагш үед хамаарна.

Урианхат аймгийг эдгээрээс гадна өөр түүх сударт бас тэмдэглэжээ. Тухайлбал, Хидан гүрний түүхэнд, Wu-niang-kai (唄娘改), Wo-lang-kai (韓朗改) хэмээн хоёр янзаар (Ляо улсын судрын 1, 3b; 6, 6a; 27, 7b; 46, 27a; 46, 31a-д) таван удаа

11 Рашид-ад-дин. Сборник летописей. Том. I, кн. 1, перевод с персидского Л.А.Хетагуров, редакция и прим. проф. А.А.Семенова. М.-Л., 1952. сс. 77, 78, 121, 123, 125, 154; Rashiduddin Fazlullah. Jami'ut-tawarikh: Compendium of Chronicles. Vol. I, part 1, English translation & annotation by W.M.Thackston. Harvard University, 1998. pp. 25, 26, 57, 59, 80

12 Рашид-ад-дин. Сборник летописей. Том. I, кн. 2, перевод с персидского О.И.Смирновой, прим., Б.И.Панкратова и О.И.Смирновой. М.-Л., 1952. с. 9, 8; Rashiduddin Fazlullah. Jami'ut-tawarikh: Compendium of Chronicles. Vol. I, part 2, English translation & annotation by W.M.Thackston. Harvard University, 1998. p. 114

13 Билэгт Л. Некоторые хронологические данные истории древних монголов //Studia Historica. To. XXIV, fasc. 12. УБ., 1990. т. 136-137; Билэгт Л. Раннемонгольские племена (этногенетические изыскания на основе устной истории). Диссертация на соискание ученой степени кандидата исторических наук. Новосибирск, 1997. сс. 39-51

тэмдэглэсэн байна. Хиданы Абужи “Тайзу хааны гуравдугаар оны өвлийн арван сарын шарагчин могой (аргын тооллын 909.11.21-ний) өдөр ... [дээд нийслэлээс] баруун хойд зүгийн Вонянгай/Униангай (嵬娘改 Wu-niang-kai) аймаг хүрдэт тэрэг өргөв” гэснээр *урианхат* аймаг Хиданы албан түүхэнд анх удаа буюу 909 онд нэр гарчээ.¹⁴

Энэ мэдээ нь *урианхат* аймаг хамаардаг Монгол Дарлекин/Дүрлүгиний талаарх «Сударын чуулган»-ы “тэд бол нэгэн цагт Эргүнэ-хун руу одож өнөржсөн нукуз (нүгүз) ба кият (хиад) хэмээх монгол аймгуудын үлдэгдэлээс өөрийн уг гарвалаа эхлүүлдэг салбар аймгууд юм. Тэд Добун-Баян ба Алан-Гоа нараас ч өмнө байсан”¹⁵ гэх мэдээтэй дүйж байгаа нь *урианхат* аймгийн үүсэл гарал VIII зуунаас өмнөх үед хамаарна гэсэн бидний саналд чухал баримт болно.

Урианхат аймаг дараа нь 963 онд Хиданы хааны ордонд буга бэлэглэж байжээ. Энэ тухай билгийн тооллын “... Инли-ийн арван гуравдугаар оны тавдугаар сарын хар нохой (аргын тооллын 963.06.23-ний) өдөр буга элбэгтэй [斡朗改 Wo-lang-kai] орноос толбот буга өргөв” гэж Ляо улсын сударт тэмдэглэсэн байдаг. Хамгийн сүүлд Хидан гүрний сүүлчийн хаан Тяньзо-ийн үед буюу Тяньцин-ий гуравдугаар оны зургадугаар сарын хөхөгчин туулай (аргын тооллын 1113.08.05-ны) өдөр [Волангай] орон элч илгээж сайн нохойгоор алба барьжээ.¹⁶

Ван Яньдэгийн аян замын тэмдэглэл дэх 卧羊梁劾特(wò yáng liáng hé tè) энэ нэрийг *урианхат* аймгийнх мөн гэж үзсэн судлаачдын санал мөн Ляо улсын сударт тэмдэглэсэн зэргээс үзвэл X–XIV зуунд тус аймгийг нангиад үсгээр хэдэн янз тэмдэглэж байжээ. Түүнчлэн Ван Яньдэгийн айлтгалд тэмдэглэсэн энэ нэрийн үсгийн тухайн үеийн (өөрөөр хэлбэл X–XIV зууны) дуудлагыг сэргээх боломжийг Эдвин Ж.Пүллиблэнкийн судалгаа олгож байна.

Түүнийхээр 卧羊梁劾特(wò yáng liáng hé tè) нэрийг хоёр үеийн байдлаар өөрөөр хэлбэл, хожуу дундад үеийн нангиад болон түрүү мандарин аялгуугаар сэргээж болох юм. Түүхэн хэлзүйн мэргэжлийн бус судлаач энэ оролдлогыг гүйцэтгэсэн гэдгийг энд онцгойлон анхаарахыг уншигчдаас хүсч байна.

Хожуу дундад үеийн (Late Middle Chinese) буюу Умард, Өмнөд Сүн улсын үед *воянляньхэтэ* нэрийг: *ɣua- jiaŋ liaŋ xhəək thəək* хэмээн харин түрүү мандарин (Early Mandarin) буюу XIV зууны нангиадаар: *wo- yaŋ* *liaŋ- xəj*

[təj] гэж уншигдахаар сэргээжээ.¹⁷

Эхний сэргээлт нь С.Жюльен-ий *ngo-liang-khe-tai* гэсэн уншлагатай нэлээд ойр дөт бол хоёрдахь *урианхат* нэртэй илүү ойр дөт дуудлагатай мэт.

Тиймээс бидний зүгээс Ван Яньдэгийн аян замын тэмдэглэлд нэр (卧羊梁劾

14 Karl A.Wittfogel, Fêng Chia-shêng. History of Chinese Society Liao (907-1125) //Transactions of the American Philosophical Society. New Series, Vol. 36, 1946. Philadelphia, 1949. pp. 98, 107, 152, 164, 337, 346, 362

15 Рашид-ад-дин. Сборник летописей. Том. I, кн. 1, перевод с персидского Л.А.Хетагуров, редакция и прим. проф. А.А.Семенова. М.-Л., 1952. с. 152

16 Karl A.Wittfogel, Fêng Chia-shêng. History of Chinese Society Liao (907-1125) // Transactions of the American Philosophical Society. New Series, Vol. 36, 1946. Philadelphia, 1949. pp. 337, 362

17 Pulleyblank Edwin, G. Lexicon of Reconstructed Pronunciation in Early Middle Chinese, Late Middle Chinese, and Early Mandarin. Vancouver-UBS Press, 1991. p. 122, 191, 304, 324, 360

特) гарсан эл аймгийг урианхат (uriyankhat?) гэж үзсэн Б.Өгэлийн саналд тал өгч байна.

Харин Ван Яньдэ нарын зам зуур дайрч өнгөрсөн *воянлянхэтэ* аймаг мөн тэдний сууж байсан, VIII–IX зууны үест уйгуруудын эзэмшиж байсан Дудушань уул хаа байсныг одоогоор найдвартайгаар олж тогтоогүй л байна. Бид өмнө Дин Цяний Говь Гурван Сайхан уул, Б.Өгэлийн Хэланьшань уул гэсэн саналыг дурдсан. Гэвч эдгээр нь судлаачдын олонхийн саналыг бас хүлээхгүй л байна.

Эргүнэ хуны монгол урианхат аймаг тэндээс нүүж гарсны дараа их төлөв Хэнтий нуруунд нутаглаж байсныг «Монголын нууц товчоон» дахь Хорилордай мэргэн, Жарчиудай өвгөнд хамаарах мэдээнээс харж болно. Тухайлбал, § 9-д: “... Burqan qaldun-u ejed burqan bosqaysan Šinči bayan Uriyangqay-dur ...” гэж бий бол § 97-д: Чингис ханыг Бүрги эрэгт нутаглаж “... büküy-dur Burqan qaldun-ača ur[i] yangqaday küün Jarčiyuday ebügen ...” хөөргөө үүрч, Зэлмэ нэрт хүүгээ дагуулан ирсэн хэмээн мэдээлж байна.¹⁸

Хорь түмэдийн Хорилардай мэргэний охин Ариг уснаа төрсөн Алан Гоа-г Түнхэлиг горхины хавь нутагт Дува сохор гуйж дүү Добу мэргэндээ авч өгсөн¹⁹ түүхэн баримт мөн “... Бөртэчонын хорин есний хөвгүүн Батачи хан нь Тан улсын Дэ Цзуны Чжэнь Юань-ий хоёрдугаар он, улаан барс жил төрөв. [Түүний удмын] Боржигидай мэргэний хорин нэгний насны хөвгүүн Добу мэргэн ...”²⁰ гэсэн XVIII зууны монгол сурвалжийн мэдээг нягтлан судлаад Добу мэргэнийг 945 он эсвэл 944 онд төрсөн²¹ гэж үзсэн судлаачдын дүгнэлтийг үндэслэвэл Урианхат аймаг Бурхан Халдунд нутаглаж байсан цаг хугацаа нь лавтай Х зууны II хагасаас урьд цаг үед хамаарч байна. Энэ нь *урианхат* аймаг болон түүний багтдаг *монгол дүрлүгинүүдийг* Добун–Баян ба Алан–Гоа нараас ч өмнө байсан гэх мэдээтэй дүйж байна.²²

Тиймээс *урианхат* аймгийг 780 иад оноос 1180 иад оныг хүртэл Бурхан Халдун буюу Хэнтийн нуруунд нутагласаар ирсэн гэж баттай хэлж болно.

Ван Яньдэгийн аялан явсан зам нь Алаша цөлийн хойгуур Их Говиор байсан нь нэлээд магадтай тул Дин Цяний Говь Гурван Сайхан уул гэж оноосон нь бараг зөв мэт, харин нэмэлт судалгаа шаардлагтай нь мэдээж.

Гэхдээ «Монголын нууц товчоон» болон «Сударын чуулган»-д тэмдэглэгдсэн *урианхат* аймгийн голлон нутаглаж асан Хэнтий нуруу хийгээд Ван Яньдэгийн аян замын тэмдэглэл дэх *воянлянхэтэ* аймгийн нутаглаж байсан гэж үзэж болох Говь Гурван Сайхан уулс хоорондоо нэлээд зайтайг анхааралдаа авах нь зүйтэй болов уу.

18 Монголын нууц товчоо. Галиглаж хэвлүүлсэн Т.Дашцэдэн //Corpus Scriptorum Mongolorum. Tom. XXI, fasc. I. УБ., 1985. § 9, т. 12, § 97, т. 40

19 Монголын нууц товчоо. Галиглаж хэвлүүлсэн Т.Дашцэдэн //Corpus Scriptorum Mongolorum. Tom. XXI, fasc. I. УБ., 1985. § 5-9, т. 11-12

20 Мэргэн гэгээн Лувсандамбижалцан. Их Монгол улсын үндсэн Алтан товч тууж оршвой. Монгол бичгээс хөрвүүлж, оршил бичиж, тайлбар, хавсралт хийсэн Д.Бүрнээ. УБ., 2006. т. 53-54

21 Пэрлээ Х. Монголын түүхийн урьд мэдэгдээгүй зарим он цагийн мэдээ – Академич Х.Пэрлээ. Эрдэм шинжилгээний өгүүлүүд. Боть И. Эрхлэн нийтлүүлсэн Д.Цэвээндорж, эмхтгэж хэвлэлд бэлтгэсэн У.Эрдэнэбат. УБ., 2001. т. 152, 154; Билэгт Л. К вопросу о достоверности родословной Чингис-хана //Studia Archeologica. Tom. XV, fasc. 10. УБ., 1995. т. 97-110

22 Рашид-ад-дин. Сборник летописей. Том. I, кн. 1, перевод с персидского Л.А.Хетагуров, редакция и прим. проф. А.А.Семенова. М.-Л., 1952. с. 152

Ашигласан сурвалж судалгааны бүтээл

1. Батсүрэн Б. Монгол-Татарын түүхийг нэхэн мөшгөх нь //Studia Historica. Tom. XXXVIII, fasc. 4. УБ., 2008. т. 59-89
2. Билэгт Л. К вопросу о достоверности родословной Чингис-хана //Studia Archaeologica. Tom. XV, fasc. 10. УБ., 1995. т. 97-110
3. Билэгт Л. Некоторые хронологические данные истории древних монголов //Studia Historica. Tom. XXIV, fasc. 12. УБ., 1990. т. 130-138
4. Билэгт Л. Раннемонгольские племена (этногенетические изыскания на основе устной истории). Диссертация на соискание ученой степени кандидата исторических наук. Новосибирск, 1997
5. Гантулга Ц, Лонжид З. Түүхийн сурвалж судлал, өнөөгийн байдал тулгамдсан асуудлууд //Монголын түүхийн сурвалж судлал: Өнөөгийн байдал, судалгааны асуудлууд (Олон улсын эрдэм шинжилгээний хурлын материал). Эрхэлсэн Ц.Гантулга. УБ., 2004. т. 6-18
6. Монголын нууц товчоо. Галиглаж хэвлүүлсэн Т.Дашцэдэн //Corpus Scriptorum Mongolorum. Tom. XXI, fasc. I. УБ., 1985
7. Мэргэн гэгээн Лувсандамбижалцан. Их Монгол улсын үндсэн Алтан товч тууж оршвой. Монгол бичгээс хөрвүүлж, оршил бичиж, тайлбар, хавсралт хийсэн Д.Бүрнээ. УБ., 2006
8. Пэрлээ Х. Монголын түүхийн урьд мэдэгдээгүй зарим он цагийн мэдээ – Академич Х.Пэрлээ. Эрдэм шинжилгээний өгүүллүүд. Боть I. Эрхлэн нийтлүүлсэн Д.Цэвээндорж, эмхтгэж хэвлэлд бэлтгэсэн У.Эрдэнэбат. УБ., 2001. т. 151-155
9. Рашид-ад-дин. Сборник летописей. Том. I, кн. 1, перевод с персидского Л.А.Хетагуров, редакция и прим. проф. А.А.Семенова. М-Л., 1952
10. Рашид-ад-дин. Сборник летописей. Том. I, кн. 2, перевод с персидского О.И.Смирновой, прим., Б.И.Панкратова и О.И.Смирновой. М-Л., 1952
11. Сүрбадрах. Монгол үндэстний язгуур үүсэл. Сүх монголчлов. Үндэстний хэвлэлийн хороо, 1988
12. Çin elçisi Wang Yen-te'nin Uygur Seyahatnamesi. Özkan Izgi. Ankara, 2000
13. Drompp M.R. Tang China and the Collapse of the Uighur Empire. A documentary history //Brill's Inner Asian Library. Vol. 13, Brill-Leiden-Boston, 2005
14. Julien S. Notices sur les pays et les étrangers, tirees des geographies et des annales chinoises; III, Les Oigours // Journal Asiatique. Ser. IV, Tome IX. 1847. pp. 50-66
15. Karl A. Wittfogel, Fêng Chia-shêng. History of Chinese Society Liao (907-1125) //Transactions of the American Philosophical Society. New Series, Vol. 36, 1946. Philadelphia, 1949
16. Ögel B. Ein Tor Nach China Im 10. JHDT //Central Asiatic Journal. Vol. VI, 1961. s. 169-181
17. Pulleyblank Edwin, G. Lexicon of Reconstructed Pronunciation in Early Middle Chinese, Late Middle Chinese, and Early Mandarin. Vancouver-UBS Press, 1991
18. Rashiduddin Fazlullah. Jami'ut-tawarikh: Compendium of Chronicles. Vol. I, part 1, 2, English translation & annotation by W.M.Thackston. Harvard University, 1998